

МОНГОЛ БА ТӨВ АЗИЙН УЛСУУДЫН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

Пүрэвдоржийн Мягмардорж*

Abstract: This article examines the current state of relations and cooperation between Mongolia and the countries of Central Asia—Kazakhstan, Kyrgyzstan, Uzbekistan, Turkmenistan, and Tajikistan—focusing on the geopolitical, economic, and socio-cultural factors that shape these interactions. The study finds that emerging trends in regional integration, expanding transport and logistics connectivity, and cooperation in energy and green development are likely to intensify in the coming years. Mongolia's multi-pillared, balanced foreign policy, along with the deepening intra-regional integration of Central Asian states, forms a key foundation for advancing bilateral and regional cooperation. Looking ahead, collaboration between Mongolia and the Central Asian countries is expected to expand on the basis of economic complementarity, strategic geographic positioning, innovative transport-logistics solutions, regional security considerations, and the goals of sustainable development. In particular, Mongolia's "Third Neighbor" policy and the new phase of Central Asian integration could help increase trade and investment flows while enhancing regional infrastructure connectivity. Overall, relations between Mongolia and the Central Asian states are steadily expanding, with clear prospects for evolving into more substantive, long-term cooperation grounded in strategic partnership and economic integration.

Keywords: Mongolia's balanced foreign policy, Central Asian countries, Levels of diplomatic & strategic relations, future prospects for bilateral relations and cooperation.

Удиртгал

Монгол Улс сүүлийн жилүүдэд Төв Азийн бүс нутгийн улс орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа идэвхтэй өрнүүлж, гадаад бодлогын тэнцвэртэй, олон тулгуурт чиглэлийг бэхжүүлэх стратеги баримтлан ажиллаж байна. Казахстан, Киргизстан, Узбекистан, Туркменистан болон Тажикистантай тогтоосон уламжлалт найрсаг харилцаа нь худалдаа эдийн засаг, тээвэр логистик, эрчим хүч, аюулгүй байдал, боловсрол, соёлын салбарт ахицтай өрнөж байна. Өнөөгийн хамтын ажиллагааны үндсэн чиглэл нь бүс нутгийн холболт болон тээвэр логистикийн шинэ гарцуудыг эрэлхийлэх, эрчим хүчний сүлжээний уялдаа холбоог нэмэгдүүлэх, уул уурхай, барилга хот байгуулалт, хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн салбарт харилцан ашигтай хөрөнгө оруулалт татахад оршиж байна. Мөн өв уламжлал, соёлын солилцоог өргөжүүлэх, аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх, ногоон болон дижитал шилжилтийн чиглэлд хамтран ажиллах сонирхол талуудын зүгээс өндөр байна. Эдгээр харилцаа хамтын ажиллагааг эрх зүйн хүрээнд баталгаажуулах тал дээр Монгол Улсын зүгээс ч тэр, Төв Азийн улсуудын зүгээс идэвх санаачилгатай ажиллаж буйг өнөөдрийн байдлаар тогтоогоод буй хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны түвшин, өндөр дээд түвшний харилцан айлчлалууд батлан харуулж байна.

Цэрэг-улс төр, санхүү эдийн засгийн нөлөө бүхий хоёр их гүрний дунд оршдог, далайд гарцгүй, геополитикийн ашиг сонирхол, аюулгүй байдал болоод эдийн засгийн нөлөөллийн хувьд хоёр хөршөөс нэн хамааралтай зэрэг байдал нь манай улсын гадаад бодлогод томоохон сорилтыг ямагт дагуулж байдаг. Иймд хоёр хөршөөс гадна бусад улсуудтай харилцах харилцаагаа идэвхжүүлэх, харилцааныхаа түвшинг шинэ шатанд гаргах зайлшгүй шаардлагатай.

* ХИС-ийн олон улсын харилцааны ахлах багш, доктор /Ph.D./

Ялангуяа өнөөгийн олон улсын харилцааны ярвигтай, ирээдүйн төлөв нь тодорхойгүй нөхцөл байдалд сайтар боловсруулсан, үр дүнтэй гадаад бодлогыг цаг алдалгүй, идэвхийлэн хэрэгжүүлэх нь бүр ч их ач холбогдолтойд тооцогдоно.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын гадаад бодлогын шийдвэр гаргах механизмд багтдаг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн Газар, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл, Гадаад Харилцааны Яам зэрэг институт Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд тусгасан “энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулах” (УИХ, 2011) тухай гадаад бодлогын тулгуур зарчмуудыг сайтар баримтлаж буйн зэрэгцээ “тэнцвэртэй гадаад бодлого”-ын зарчмыг ч мөрдлөг болгон ажиллах болсон. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн зүгээс гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хангахын тулд шийдвэр гаргах механизмд багтдаг бусад институттэй нягт хамтран ажиллаж, гадаад бодлогын зорилго, зорилтуудыг төрийн тэргүүний түвшинд амжилттай хэрэгжүүлэхийн сацуу, гадаад бодлогод баримтлах чиглэлд заасан улс орнуудтай тогтоосон харилцааны түвшинг шинэ шатанд гаргах тал дээр ч анхааран ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын 14-3-т *“Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох”* (УИХ, 2011) хэмээн заасан чиглэл дотор саяхныг болтол “гээгдээд” байсан Төв Азийн улсуудтай харилцах, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх чиглэлийг 2023 оноос эхлэн илтэд сэргээж хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргаж чадлаа.

Олон тулгуурт, тэнцвэртэй гадаад бодлогын хүрээнд Төв Азийн улсуудтай тогтоож буй харилцаа нь Монголын гадаад бодлогын орон зайг өргөжүүлэх, худалдаа эдийн засаг, тээвэр логистикийн шинэ эх үүсвэр, гарц гаргалгааг бий болгоход ихээхэн ач холбогдолтой. Төв Ази нь газар зүйн хувьд ойр бүс нутаг төдийгүй гарал угсаа, түүх, соёлын үндэс нь манай улстай олон талаар огтлолцдог учраас харилцаагаа өргөжүүлэн тэлэх бүрэн боломжтой. Төв Азийн таван улс болох Казахстан, Узбекистан, Киргизстан, Туркменистан, Тажикистан нь Монгол Улсын хувьд “гуравдагч хөршийн бодлого”-ын хүрээнд ч онцгой байр эзлэх учиртай. Ази-Европыг холбосон транзит бүс болох 4 сая орчим хавтгай дөрвөлжин километр газар нутаг, эрчим хүчний арвин нөөц, 80 сая орчим хүн ам бүхий зах зээл зэрэг нь Монгол Улсын энэ бүс нутаг дахь харилцаа, хамтын ажиллагааны олон талын хөшүүрэг болох учиртай. Иймээс Монгол Улс болон Төв Азийн улсуудын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар судлахыг зорьлоо.

Монгол Улс болон Төв Азийн улсуудын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал

Хүйтэн дайны төгсгөлд ЗХУ задран унаснаар хуучнаар Дундад Ази буюу өнөөгийн Төв Азийн улсууд тусгаар тогтнолоо тунхаглан зарлаж, гадаад бодлогоо харьцангуй бие даасан байдлаар явуулах болсон. Үүнтэй зэрэгцээд Монгол Улсын зүгээс шинээр тусгаар тогтносон Төв Азийн улсуудтай дипломат харилцаа тогтоож, харилцаа, хамтын ажиллагааны шанг татсан билээ.

XXI зууны эхэн үеэс Төв Ази нь их гүрнүүдийн геополитикийн ашиг сонирхлын огтлолцлол бүхий Евразийн орон зайн стратегийн чухал зангилаа бүс болон хувирсан. БНХАУ-ын “Бүс ба Зам” санаачилга нь бүс нутгийн дэд бүтэц, худалдааны урсгалыг өөрчлөх томоохон хүчин зүйл болж байгаа бол ОХУ-ын хувьд Хамтын Аюулгүй Байдлын Гэрээний Байгууллага,

Евразийн Эдийн Засгийн Холбоо зэрэг олон талт механизмыг ашиглан бүс нутгийн интеграцын үйл явцыг өөрийн геополитикийн орон зайд хадгалахыг эрмэлзэж байна. Үүний зэрэгцээ Турк Улс нь Түрэг хэлтнүүдийн хамтын ажиллагааны байгууллагуудын (Түрэгийн Улсуудын Байгууллага, ТУРКСОЙ, Түрэгийн Зөвлөл) идэвхжилтээр дамжуулан “Зүүн–Баруун тэнхлэгийн” шинэ соёл-улс төрийн интеграцын санаа дэвшүүлж, өөрийн нөлөөллийн хүрээг өргөжүүлэх хандлагатай байна. (Maksutov, 2021)

Барууны орнуудын хувьд Европын Холбооны зүгээс “Global Gateway” санаачилга, АНУ “С5+1” платформоор дамжуулан Төв Азид эдийн засаг, эрчим хүч, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлж, Хятад–Оросын нөлөөллийн тэнцвэрийг хангах стратеги баримталж байгаа талаар АНУ-ын Албани Их Сургуулийн профессор Т.Кассенова бичиж тэмдэглэсэн байна. (Kassenova, 2021)

Геостратегийн ийм өрсөлдөөнтэй орчин Монгол Улсад тодорхой хэмжээний эрсдэл үүсгэхээс гадна бодитой боломжийг ч нээж өгнө. Монгол Улс эдгээр өрсөлдөөнд шууд татагдахаас зайлсхийх ёстой ч бүс нутгийн эдийн засаг, дэд бүтцийн интеграцид идэвхтэй, ухаалаг оролцсоноор өөрийн гадаад бодлогын уян хатан байдлыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой. (Cooley, 2018) Тэгвэл Евразийн чиглэлээр судалгаа хийдэг, Францын түүхч, улс төр судлаач, Марин Лорель “...сүүлийн арван жилд Төв Азийн улс орнуудын интеграцын үйл явц эрчимжиж, бүс нутгийн эдийн засгийн харилцаа, дипломат яриа хэлэлцээ, тээвэр логистикийн уялдаа холбоо өргөжиж буй нь Монголд шинэ стратегийн боломжуудыг нээж өгч байна...” хэмээн 2020 онд хэвлүүлсэн “Төв Азийн бүс нутаг: геополитикийн хөшүүрэг ба динамик” өгүүлэлдээ онцлон тэмдэглэжээ. (Laruelle, 2020)

Манай улсын хувьд Төв Азийн таван улс нь Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 14-3-т заасан чиглэлээр зогсохгүй, “гуравдагч хөршийн бодлого”-ын хүрээнд онцгой байр суурь эзлэх учиртай. Казахстан улсын эдийн засгийн өсөлт, байгалийн нөөц баялаг, геостратегийн байр суурь; Узбекистаны ерөнхийлөгчийн шинэчлэлийн бодлого, хүн амын тоо болоод зах зээлийн багтаамж; Киргизстаны ардчилсан тогтолцоо болон түүх соёлын төстэй байдал; Тажикистаны аюулгүй байдлын онцлог, сэргээгдэх эрчим хүчний туршлага; Туркменистаны байгалийн хий, эрчим хүчний томоохон нөөц зэрэг нь Монгол Улсын бүс нутгийн харилцаанд олон талын хөшүүрэг болж байна.

Ийм ч учир манай талаас энэ чиглэлд сүүлийн үед онцгой анхааран ажиллаж хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны түвшинг шинэ шатанд гаргаад байна. Өнөөдрийн байдлаар Төв Азийн улсуудтай манай талаас тогтоогоод харилцаа, хамтын ажиллагааны түвшинг дор дурдвал:

Казахстан: Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн урилгаар Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч К.Токаев 2024 оны 10 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд Монгол Улсад төрийн айлчлал хийсэн. Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн тэргүүний түвшинд 2008 оноос хойш 16 жилийн дараа хэрэгжсэн энэхүү айлчлал нь Монгол, Казахстаны харилцаа, хамтын ажиллагааны түүхэнд нэгэн шинэ хуудсыг нээхэд чухал ач холбогдолтой болсон. (ЕТГ., 2024) Төрийн айлчлалын хүрээнд хоёр улсын харилцааны түвшинг шат ахиулан “Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал”-ыг байгуулсан нь айлчлалын гол үр дүн болсон юм. Ингэснээр Монгол Улсын хувьд “стратегийн түншлэл”-ийн харилцаа тогтоосон 9 дэх улс болсон.

Узбекистан: Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2024 онд Узбекистан Улсад хийсэн төрийн айлчлалын хариу айлчлал болгож Узбекистаны Ерөнхийлөгч Шавкат Мирзиёев

2025 оны 06 дугаар сард Монгол Улсад төрийн айлчлал хийсэн нь хоёр улс дипломат харилцаа тогтоосноос хойш Узбекистаны талаас хийсэн төрийн тэргүүний түвшний анхны айлчлал болсон юм. Энэхүү айлчлалын хүрээнд Узбекистан Улс нь Төв Азийн бүс нутаг дахь манай улсын анхны *“Иж бүрэн түншлэл”*-ийн харилцаатай орон болсон талаар Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хэвлэл мэдээллийн байгууллагад өгсөн үгэндээ онцлон тэмдэглэжээ. (ЕТГ, 2025) Мөн талууд айлчлалын хүрээнд Монгол, Узбекистаны харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх 15 баримт бичгийг байгуулсан ажээ.

Киргизстан: Киргизийн Ерөнхийлөгч С.Жапаровын 2023 оны 07 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд Монгол Улсад хийсэн төрийн айлчлал (энэ айлчлал нь Киргизийн талаас 21 жилийн дараа хийсэн төрийн тэргүүний айлчлал), Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2025 оны 07 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд хийсэн хариу айлчлалын үр дүнд мөн л *“Иж бүрэн түншлэл”*-ийн харилцаа тогтоосон. Айлчлалын үеэр талууд харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхтэй холбоотой 10 гаруй баримт бичигт гарын үсэг зуржээ. (Ж.Болор, 2025)

Ийнхүү энэ бүс нутагт хоёр ч улстай *“Иж бүрэн түншлэл”*-ийн харилцааг тогтоож, харилцааны түвшинг шинэ шатанд гаргав.

Туркменистан: 2024 оны 10 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Туркменистан Улсын Ерөнхийлөгч С.Бердымухамедовын урилгаар тус улсад төрийн айлчлал хийсэн бол 2025 оны 06 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд Туркменистаны Ерөнхийлөгч С.Бердымухамедов Монгол Улсад хариу төрийн айлчлал хийсэн нь хоёр улсын хооронд 1992 онд дипломат харилцаа тогтоосноос хойшх хугацаанд тус улсын төрийн тэргүүний түвшинд хэрэгжсэн анхны айлчлал байсан юм. (ЕТГ., Туркменистан Улсын Ерөнхийлөгч Сердар Бердымухамедов Монгол Улсад төрийн айлчлал хийнэ, 2025) Уг айлчлалын хүрээнд хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бэхжүүлж, худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, гадаад харилцаа, хөнгөн үйлдвэрлэл, эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан зэрэг салбарын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн Засгийн газар болон байгууллага хоорондын баримт бичгүүдэд гарын үсэг зуржээ.

Тажикистан: Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Тажикистан Улсын Ерөнхийлөгч Эмомали Рахмоны урилгаар 2025 оны 07 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд тус улсад төрийн айлчлал хийж, үр дүнд нь Төрийн тэргүүн нар *“Найрсаг харилцаа, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Тажикистан Улсын хамтарсан мэдэгдэл”* гаргасан. Энэхүү айлчлал нь 1992 онд дипломат харилцаа тогтоосноос хойш манай талаас төрийн тэргүүний түвшинд хийсэн анхны айлчлал болсноороо онцлог болсон юм. (ЕТГ, “Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Тажикистан Улсад төрийн айлчлал хийнэ”, 2025) Мөн айлчлалын хүрээнд харилцаа, хамтын ажиллагааг хөдөө аж ахуй, зам тээвэр, эрчим хүч, аялал жуулчлал зэрэг салбарт өргөжүүлэн хөгжүүлэх 11 баримт бичигт гарын үсэг зурсан байна. Ерөнхийлөгч Эмомали Рахмони 2026 онд Монгол Улсад төрийн айлчлал хийхээ албан ёсоор мэдэгдсэн.

Монгол ба Төв Азийн улсуудын хоёр талт харилцааны хөгжлийн боломжит шинэ чиглэлүүд

Төв Азийн улсууд байгалийн баялагт түшиглэсэн эдийн засагтай бөгөөд дэд бүтэц, эрчим хүчний интеграц эрчимтэй өрнөж байна. Монгол Улстай харилцах худалдаа харьцангуй бага

боловч өсөх хандлагатай, ялангуяа Казахстан болон Узбекистантай худалдаа, тээвэр логистик идэвхжиж буй талаар Азийн Хөгжлийн Банкны 2021 оны судалгаанд дурджээ. (ADB, 2021)

Төв Азийн орнуудтай тогтоосон хоёр талт харилцаанд Казахстан Улс тэргүүлэх байр суурь эзлэдэг. Монгол болон Казахстан харилцаа, хамтын ажиллагаа нь уул уурхай, тээвэр логистик, боловсрол, соёлын салбар зэрэг өргөн хүрээг хамрах боломжтой. Тухайлбал, Казахстангаар дамжиж Европ руу гарах тээврийн шинэ чиглэлүүд Монголын хувьд стратегийн ач холбогдолтой. Узбекистантай тогтоосон хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимжиж, хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, худалдааны салбарт нэлээд ахиц гарсан. Киргизстантай харилцах харилцаа нь иргэний нийгмийн солилцоо, ардчиллын туршлага, финтекийн болон аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах боломжтой. Тажикистантай аюулгүй байдал, терроризмын эсрэг хамтын ажиллагаа нэн чухал бол Туркменистантай эрчим хүч, байгалийн хийн салбарын хамтын ажиллагааны боломж нээлттэй хэвээр байна.

Гэвч худалдааны эргэлт өнөөг хүртэл харьцангуй бага хэмжээнд хадгалагдсаар ирсэн. Үүний гол шалтгаан нь хоёр талын эдийн засаг ижил төстэй — уул уурхай давамгайлсан бүтэцтэй, мөн тээвэр логистикийн шууд гарц байхгүй зэрэг хүчин зүйлс юм. Далайд гарцгүй орнууд хоорондын худалдаа байгалийн жамаараа өртөг өндөртэй байдаг тул энэ бэрхшээлийг зөвхөн шинэ тээврийн дэд бүтэцтэй уялдуулан шийдвэрлэх боломжтой.

Тээвэр логистик: Монгол–Төв Азийн харилцааны гол зангилаа

Монголын талаарх стратегийн сонирхол нэмэгдэж буй нэг салбар бол Евразийн тээврийн сүлжээнд холбогдох асуудал юм. “Төв коридор”, “Хойд коридор” зэргийг холбох боломж нь Төв Азийн орнууд болон Монголын аль алинд транзит ач холбогдолтой байх талаар Орос ба Евроази судлалын Девис Төвийн судлаач Ж.Л.Вильсон бичиж тэмдэглэсэн байна. (Wilson, 2016)

Евразийн эдийн засгийн интеграцид Монгол Улс оролцохын тулд тээвэр логистик хамгийн чухал салбар юм. Монгол–Орос–Казахстан чиглэлийн төмөр зам Европ руу гарах хамгийн бодитой гарц хэвээр байна. Нөгөө талаар Монгол–Хятад–Төв Ази чиглэлийн коридор нь” Бүс ба Зам” санаачилгатай уялдаж, Монголын тээврийн сүлжээг бүс нутгийн сүлжээтэй холбох боломжтой. Мөн Узбекистан–Киргизстан–Монгол чиглэлээр яригдаж буй шинэ замын төсөл хэрэгжсэн тохиолдолд Монголын транзитын ач холбогдол эрс нэмэгдэнэ. Эдгээр коридорын хөгжлийн үр дүнд Монгол Улс зөвхөн Төв Азийн улсуудаас бараа импортлох, экспортлох боломжтой төдийгүй Евразийн тээврийн томоохон зангилаа болон хувирах боломжтой.

Соёл, боловсрол, хүн хоорондын харилцаа: Итгэлцлийн хамгийн бат бөх гүүр

Кембрижийн Их Сургуулийн профессор, Төв Ази, Монгол судлалаар мэргэшсэн судлаач Дэвид Снит “Монгол ба Төв Азийн соёлын улс төр” хэмээх судалгааны бүтээлдээ: *“Төв Азийн улсуудтай хэл, соёлын ижилсэл, нүүдлийн уламжлалт өв, түрэг ба монгол угсаатны судлал нь хүмүүнлэгийн харилцааг өргөжүүлэх боломж олгодог”* хэмээн бичсэн байна. (Sneath, 2019) Төв Азийн ард түмэнтэй Монгол Улс тал нутгийн нүүдэлчдийн соёл, угсаатны гарал язгуур, домог зүй, түүхэн уламжлалаараа нягт холбоотой. Түрэг хэлт ард түмэнтэй түүхэн холбоотой байдал нь хүн хоорондын харилцааг өргөжүүлэх, харилцан ойлголцлын хөрсийг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй. Соёлын хамтын ажиллагаа нь ихэнхдээ улс төр, эдийн засгийн хэлэлцээний суурь болдог учраас Монголын хувьд энэхүү боломжийг өргөн хүрээнд ашиглах нь зүйтэй. Соёлын

арга хэмжээ, спортын хамтарсан тэмцээн, нүүдлийн соёлын өвийг хамтран сурталчлах зэрэг нь харилцааг зөөлөн, тогтвортой хэлбэрээр хөгжүүлэхэд нэмэр болно.

Сорилтууд болон ирээдүйн боломж

Монгол–Төв Азийн харилцаанд тулгарч буй сорилтуудын нэг бол тээврийн өртөг өндөр, дэд бүтцийн холболт сул байдал юм. Мөн эдийн засаг ижил төстэй учир яг нэг төрлийн бүтээгдэхүүн экспортлох, зах зээл булаалдах эрсдэл бий. Геополитикийн өрсөлдөөн, ялангуяа ОХУ, Хятад, Турк, Барууны улс орнуудын нөлөөний огтлолцол нь Монголын гадаад бодлогын маневрыг заримдаа хязгаарлаж болзошгүй.

Гэсэн хэдий ч эдгээр сорилтууд нь шинэ боломжуудыг нээж өгөх талтай. Монгол Улс Төв Азийн улсуудтай хамтарч:

- Евразийн тээврийн зангилаа болох,
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэгч болон өргөжих,
- Органик хүнсний экспортын зах зээлийг нээх,
- Аялал жуулчлал, нүүдэлчдийн соёлын хамтарсан брэнд бий болгох,
- Технологи, финтек, боловсролын солилцоог өргөжүүлж чадах бүрэн боломжтой.

Дүгнэлт

Монгол Улс ба Төв Азийн улсуудын харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд эрх зүйн хувьд эрс сайжирч, хоёр талын өндөр дээд хэмжээний айлчлал идэвхжсэнээр хоёр болон олон талт харилцаа агуулгын хувьд баяжиж, харилцан итгэлцсэн харилцааны загвар болон төлөвшиж байна. Цаашид эдийн засаг, геополитик, тээвэр логистик, соёл, боловсролын олон салбарт Монгол Улс болон Төв Азийн улсуудын харилцаа, хамтын ажиллагаа хөгжих боломжтой. Энэ бол зөвхөн худалдаа, тээвэр логистикийн асуудал биш, энэ бол нүүдэлчдийн соёлын нийтлэг уламжлал, Евразийн орон зай дахь харилцан хамаарал, стратегийн тогтвортой байдлын цогц бодлого юм. Төв Азийн бүс нутгийн интеграцид Монгол Улс идэвхтэй оролцсоноор гадаад бодлогын уян хатан байдал нэмэгдэж, эдийн засгийн төрөлжилт сайжирч, Евразийн тээврийн сүлжээнд эзлэх байр сууриа бататгах боломж нээгдэнэ.

Төв Азийн улсуудтай байгуулж буй найрсаг харилцаа, урт хугацааны хамтын ажиллагаа нь Монгол Улсын бүс нутаг дахь оршихуйн стратегийн баталгаа хэвээр байх бөгөөд ирэх арван жилд энэ чиглэл улс орны хөгжилд улам бүр чухал байр суурь эзлэх нь дамжиггүй.

НОМ ЗҮЙ:

Монгол хэлээр:

1. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. УИХ. УБ., 2011 он.
2. Ж.Болор. Ерөнхийлөгч У_Хүрэлсүхийн Бүгд Найрамдах Киргиз Улсад хийсэн төрийн айлчлал өндөрлөлөө. МОНЦАМЭ Агентлаг. УБ., 2025 он.
3. ЕТГ. “Бүгд Найрамдах Казакстан Улсын Ерөнхийлөгч Монгол Улсад төрийн айлчлал хийнэ”. УБ., 2024 он.
4. ЕТГ. “Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Шавкат Мирзёев нар Иж бүрэн түншлэлийн харилцаа тогтоосноо зарлалаа”. УБ., 2025 он.
5. ЕТГ. “Туркменистан Улсын Ерөнхийлөгч Сердар Бердымухамедов Монгол Улсад төрийн айлчлал хийнэ”. УБ., 2025 он.
6. ЕТГ. “Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Тажикистан Улсад төрийн айлчлал хийнэ”. УБ., 2025 он.

Англи хэлээр:

1. Asian Development Bank. (2021). *CAREC 2030: Connecting the Region for Shared and Sustainable Development*. Manila: ADB.
2. Cooley, A., & Laruelle, M. (2018). *The Impact of Great Power Competition on Central Asia: China's Rise and the Future of U.S. Strategy*. Washington DC: The Atlantic Council.
3. Kassenova, T. (2021). *U.S.–Central Asia Relations and the C5+1 Platform*. Carnegie Endowment
4. Laruelle, M. (2020). *Central Asian Regionalism: New Geopolitical Drivers and Dynamics*. Washington, DC: George Washington University, Central Asia Program.
5. Maksutov, R. (2021). *Regional Power Dynamics in Central Asia*. Central Asia Economic Review, 23(4), 10–22.
6. Sneath, D. (2019). *The Politics of Culture in Mongolia and Inner Asia*. Inner Asia, 21(2), 175–195.
7. Wilson, J. L. (2016). The Eurasian Economic Union and China's silk road: implications for the Russian–Chinese relationship. *European Politics and Society*, 17(sup1), 113–132